

*Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын төсөлд санал ирүүлнэ үү.*

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Усны нөөцийн хэлтэс, 51-266305

**Төсөл**

## БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2018 оны ..... -р сарын  
..... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

### Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.17 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

“Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/33 дугаар тушаалын хавсралтын “50 хүртэлх” ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс “360 000 төгрөг” гэснийг “50 000 төгрөг” гэж, “50-100” ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг “490 000 төгрөг” гэснийг “100 000 төгрөг” гэж тус тус өөрчилсүгэй.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

## ТАНИЛЦУУЛГА

“Тушаалд өөрчлөлт оруулах тухай”  
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын төсөл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.17 дахь хэсэгт “ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан байдаг.

2016 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын "Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай" А/33 дугаар тушаалаар "ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс"-ийг шинэчлэн баталж, уг тушаалыг Хууль зүйн яамны улсын нэгдсэн бүртгэлийн 3421 дугаарт /нэмэлт өөрчлөлт-1/ бүртгүүлсэн.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд “Монгол-Ус” ТӨААТҮГ, Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гарган өгч байгаа бөгөөд дүгнэлт гаргасны үйлчилгээний хөлсийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/33 дугаар тушаалын дагуу тооцон авч байна.

Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлстэй холбоотойгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/33 дугаар тушаалд өөрчлөлт оруулах талаар ирүүлсэн мэдээ, хүсэлт, саналын дагуу холбогдох тооцоо, судалгааг хийж “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” тушаалд өөрчлөлт оруулах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын төслийг боловсруулсан болно. Энэхүү тушаалын төсөлд А/33 дугаар тушаалын хавсралтын “50 хүртэлх” ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс “360 000 төгрөг” гэснийг “50 000 төгрөг” гэж, “50-100” ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг “490 000 төгрөг” гэснийг “100 000 төгрөг” гэж өөрчлөхөөр тусгасан.

“Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалыг баталснаар Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

**Байгаль орчин, аялал жуулчлалын яам**